

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн
125 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

БАТЛАВ: ЗАХИРАЛ

Х.БАЯРБИЛЭГ



Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын
Од цогцолбор сургууль

Огноо: 2020-01-06

**“ХИЧЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ”
БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ, НОМ ХЭВЛЭЛ,
ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх бичиг хэргийн материал, ном хэвлэл

Төслийн дугаар: ДУАДСОЦС/202012013

Харьцуулалт/
гэрээний дугаар: ДУАДСОЦС/202012013 №14

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын Од цогцолбор сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” бичиг хэргийн материал, ном хэвлэл нийлүүлэх тухай битүүмжлэл бүхий үнийн саналаа цахимаар ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 / тавин мянга / төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим систем ашиглан худалдан авна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны **08 цаг 55 минутаас** өмнө www.tender.gov.mn сайт ашиглан цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн **09 цаг 30 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. -Тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Дархан-Уул, Дархан сум 16-р баг , 1 дүгээр хороолол, Од цогцолбор сургууль хичээлийн А байр. Багш хөгжлийн өрөө.

Утас: 88064224.

Имэйл хаяг: od.darkhan@esrp.edu.mn,

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар
ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа: Хялбаршуулсан цахим тендер болно. Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Цаг: 08 цаг 55 минут
ТОӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа: Байгууллагын хаяг: Дархан-Уул, Дархан сум 16-р баг , 1 дүгээр хороолол, Од цогцолбор сургууль Давхар болон өрөөний дугаар: Хичээлийн А байр. 2-р давхар “Багш хөгжлийн өрөө” Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут
ТОӨЗ 2.3	Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын товч тодорхойлолт 2. ААН-ын улсын бүртгэлийн гэрчилгээний наториатаар баталгаажуулсан хуулбар 3. Харьяа татварын албаны тодорхойлолт 4. Харьяа нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт 5. Шүүхийн шийдвэрт өр төлбөргүй тодорхойлолт 6. Сүүлийн 1 жилд тухайн тендерт оролцогчтой холбоотой гарсан аливаа зарга маргааны талаарх мэдээлэл, маргааны тоо 7. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх /бараа нийлүүлэх хугацааны хамт/
ТОӨЗ 4.1	Үнийн тохируулга хийгдэхгүй ба санал болгосон үнэ нь гэрээний хугацаанд тогтмол байна.
ТОӨЗ 5.1	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан байх ба техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
ТОӨЗ 5.2	Нийт төсөвт өртгийн 2%-иар тендерийн баталгааг харилцагч банкаар гаргуулан ирүүлэх.Тендерийн баталгааны дүн: 312486 төгрөг . Тендерийн баталгааг тендерийн хүчинтэй хугацаанаас 28 хоногийн дараа цуцлана.

ТӨӨЗ 6.1	Тендерийн хүчинтэй байх хугацаа үнийн санал ирүүлснээс хойш 30 хоног.
ТӨӨЗ 7.2	Нийт төсөвт өртөг: Улсын төсвийн санхүүжилт 15 624 300 төгрөг. Багцгүй.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Чанарын өндөр шаардлага хангасан, стандартад нийцсэн байх.
2. **Стандарт:** Олон улсын стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
3. **Баглаа, боодол:** Үйлдвэрийн лац, тэмдэг бүрэн, хөдлөөгүй, хугацаа дуусаагүй, барааны бүрэн бүтэн байдал хэвийн, хэмжээс жин тодорхой
4. **Бараа хүргэх газар:** Од цогцолбор сургуулийн хичээлийн А байр.
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** 2020-02-01-нээс 2020-12-31

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Д/Д	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Байгууллагад барааг хүргэх эцсийн цэг	Инкотерийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Бичгийн цаас	80gsm-DoubleA-A4, дүйцэхүйц	150	Боодол	Хичээлийн А,Б, В байр	Гэрээ хийдгдсэн өдрөөс	Жилийн турш	
2	Өнгийн цаас	A4, дүйцэхүйц	10	Боодол				
3	A3 бичгийн цаас	DoubleA A3, дүйцэхүйц	8	Боодол				
4	A3фото цаас	Showe Regius paper A3, дүйцэхүйц	8	Боодол				
5	Хавтас	60 хуудастай	30	ш				
6	Нуруу	28мм-тэй дөрвөлжин	30	ш				
7	Нуруу	7,5мм-тэй дөрвөлжин	20	ш				
8	Ламинаторын цаасA3	Speed A3, дүйцэхүйц	4	Боодол				
9	Ламинаторын цаасA4	Speed A4, дүйцэхүйц	4	Боодол				
10	Фото цаас200г	Showe Regius paper A4, дүйцэхүйц	25	Боодол				
11	Фото цаас140г	Showe Regius paper A4, дүйцэхүйц	25	Боодол				

12	Цэнэглэгч хор	HP,samsung	10	ш			
13	Катриж	HP,samsung	4	ш			
14	Өнгөт хор	L360,380,1390	120	ш			
15	Шохой	№100 солонгос ба түүнтэй дүйцэхүйц	100	Хайрцаг			
16	Слайд	Film for binding 10/100-A4, дүйцэхүйц	2	Боодол			
17	Хавтас	40 хуудастай	10	ш			
18	Нуруу	10мм дөрвөлжин	25	ш			
19	Каноны хор	CanonIR-2016	2	ш			
20	Каноны хор	Куосера-T180	2	ш			
21	Самбар	120*240 ногоон,цагаан 2 талтай	8	ш			
22	HDMI холбогч	10м стандарт хангасан	3	ш			
23	Цоологч	A4 стандарт хангасан	3	ш			
24	Ламинаторын машин	стандарт хангасан	2	ш			
25	Эргэдэг үдээсний машин	стандарт хангасан	5	ш			
26	Цаас зүсэгч	A4, стандарт хангасан	3	ш			
27	Самбарын шугам,гортиг	стандарт хангасан	4	ком			
28	Үйлний хайч	стандарт хангасан	15	ш			
29	Муруй эсгүүрийн шугам	стандарт хангасан	4	ш			
30	Гурвалжин шугам	стандарт хангасан	1	ш			
31	Оёдлын машин	singer шулуун хөл машин-1 цахилгаан олон үйлдэлт-1	2	ш			
32	Өнгөт принтер	L360,3110-тай дүйцэхүйц	3	ш			

33	Глобус	Улс төрийн глобус том	3	ш			
34	Улс төрийн карт	90*120	3	ш			
35	Технологийн хичээлийн дасгал ажлын дэвтэр	A4 хэмжээтэй, өнгөт хэвлэл	200	ш			
36	Волейболын бөмбөг	Молтен	3	ш			
37	Сагсны бөмбөг	Молтен	3	ш			
38	Математикийн 6000 тест	Ш.Сарангэрэл 2016	30	ш			
39	Математик сонгон VIII-IX	Б.Хасбаатар 2019	38	ш			
40	Математик VIII-IX	Б.Хасбаатар 2019	20	ш			
41	Математик сонгон VI-VII	Б.Сандагдорж 2019	38	ш			
42	Математик сонгон VI-VII	Б.Хасбаатар 2019	38	ш			
43	Математик VIII	Б.Хасбаатар 2020	38	ш			
44	Дасгал ажлын дэвтэр 1,2 дэвтэр	Х.Сайнжаргал 2020	30	ш			
45	Алгебр VI- VIII, IX-X, XI- XII	Б.Сандагдорж 2018	10	ш			
46	Англи хэлний сурах бичиг	Upstream- Beginner A1+	10	хос			
47	Биологийн сурах бичиг	6-р анги дасгал ажил-2018 он, С.Болорцэцэг, Г.Зул	2	ш			
48	Биологийн сурах бичиг	7-р анги дасгал ажил-2018 он С.Болорцэцэг, Г.Зул	2	ш			
49	Биологийн сурах бичиг	8-р анги дасгал ажил-2018 он, С.Болорцэцэг, Г.Зул	2	ш			
50	Биологийн ном	Кэмпэл I, II боть, орчуулсан Болдгийв-2019	1	ш			
51	Арганик хими- 1,2	Н.Цэвэгсүрэн, Д.Монхообор- 2018-2019	2	ш			

52	Арганик хими	Н.Цэвэгсүрэн, Д.Монхообор- 2018-2020- Бодлогын	10	ш				
53	Ерөнхий хими	А.Перлэв- Ойдов, Н.Наранцогт	10	ш				
54	Химийн олимпиадын жишиг даалгавар	Нийслэлийн химийн сургагч багш нарын бүтээл-2019	5	ш				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]